



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Сайнцагаан сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДУА-2026/11/НА-СТА-ТТЗ

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох
Утас: 70592439
Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Батсайхан
Утас: 70592225
Цахим хаяг: Batsaikhant@audit.gov.mn

Ахлах аудитор: Ж.Угтахбаяр
Утас: 70593113
Цахим хаяг: Ugtakhbayarj@audit.gov.mn

Аудитор: Э.Пүрэвбаатар
Утас: 70593110
Цахим хаяг: purevbaatare@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn

Дундговь аймаг

2026 он

1.Аудитын санал дүгнэлт



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2026.04.01 № 97

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ
ДАРГА С.БАТ-ОРГИЛ ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Дундговь аймгийн Сайнцагаан сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Дундговь аймгийн Сайнцагаан сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

1. Хоршоо хөгжүүлэх сан дээр зээлдэгч гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу 8.9 сая төгрөгийн үндсэн зээл, хүүгийн төлбөр хугацаа хэтэрсэн байхад төлүүлээгүй.
2. Нийт татварын орлогын батлагдсан төлөвлөгөөнөөс 933.9 сая төгрөгийн төгрөгийн орлогыг дутуу төвлөрүүлсэн.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 41.2, 41.2.1-т, Иргэний хуулийн 222.4, 222.5-д, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дугаар тушаалаар батлагдсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3.4.11-д, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59.1.19-д заасан заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Залруулагдаагүй алдаа нь урьдчилан тооцоолсон материаллаг байдлын түвшнээс 8 дахин их, татварын орлого нийт дүнгээр тасарсан, аж ахуйн нэгж, байгууллагаас нийгмийн хариуцлагын хүрээнд олгосон хандивыг орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлээгүй, зээлдэгч нь гэрээний үүргээ биелүүлээгүй байхад холбогдох арга хэмжээ авч ажиллаагүй, Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг зөрүүтэй тайлагнасан зэрэг нь шинж чанар агуулгын хувьд материаллаг, оршин байх, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх үүрэг

4826050328

батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад Монгол улсын Засгийн газрын шийдвэрээр 2025 оны 01 сарын сарын 01-ээр төрийн албаны үндсэн цалин нэмсэнтэй холбоотой төсөвт байгууллагуудын цалингийн зардал өмнөх оноос 691.5 сая төгрөгөөр өссөн байна. Сайнцагаан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны орон нутгийн төсөв батлах тухай 30 дугаар тогтоолоор тайлант онд 11,065.4 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 10,131.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 92 хувиар биелүүлж, 933.9 сая төгрөгөөр орлого тасарсан байна. Энэ нь газрын төлбөр 1,314.1 сая төгрөгөөр тасарч газрын ногдуулалт илүү хийгдсэнтэй холбоотой.

Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад 2025 оны сүүлээр төсвийн орлого бүрдэлтэй уялдуулан төсвийг хэмнэлттэй хуваарилж, зарцуулах, төсвийн сахилга батыг чангатгах, төрийн санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор төрийн сангийн дансны гүйлгээний эрхийг хаасантай холбоотой төсөвт байгууллагуудын үйл ажиллагааны зардалтай холбоотой өр төлбөр өсч, өмнөх оноос 33.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 9 зорилт, 121 арга хэмжээг хэрэгжүүлэхээс 103 арга хэмжээг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 85 хувьтай үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний

баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруулэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

мянган төгрөг

Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	4,046,078.9	7,905,394.2
1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	2,889,032.2	5,441,372.6
1.1.3 АВЛАГА	747,252.3	1,919,298.1
1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	333,304.4	391,268.5
1.1.7 БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	76,490.0	153,455.0
1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,789,529.8	2,758,035.1
1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,789,529.8	2,758,035.1
1.2.2.02 Биет хөрөнгө	2,576,101.0	2,545,747.2
1.2.2.03 Биет бус хөрөнгө	213,428.7	212,287.9
1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	6,835,608.6	10,663,429.3
2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР	185,972.8	79,296.9
2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	185,972.8	79,296.9
2.1.1.03 Өглөг	185,972.8	79,296.9
2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,649,635.8	10,584,132.4
2.2.1 Засгийн газрын хувь оролцоо	6,649,635.8	10,584,132.4
2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал	677,666.3	677,666.3
2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн	5,863,750.5	9,798,247.1
2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	108,219.0	108,219.0
2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	6,835,608.6	10,663,429.3

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

мянган төгрөг

Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	11,379,343.4	12,146,677.1
1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	9,157,629.8	10,131,543.8
1.1.1.03.1 Орлогын албан татвар	8,473,549.6	9,383,913.4
1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар	8,473,549.6	9,383,913.4
1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	273,425.3	314,781.2
1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	410,654.9	432,849.2
1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	796,593.3	2,015,133.3
1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.0	272,625.3
1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,425,120.4	0.0
1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	8,453,848.8	7,994,356.7
1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	8,453,848.8	7,994,356.7
1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,573,874.1	6,387,151.2
1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,135,011.5	1,752,868.4
1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	140,291.1	213,914.2
1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,999,382.1	2,585,263.4
1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	191,842.2	63,920.0
1.1.2.01.1.05 Нормативт зардал	0.0	209.0
1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	194,435.0	398,956.8
1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	4,520.0	9,500.0
1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	111,820.5	523,889.0
1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	796,571.7	838,630.4
1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,879,974.8	1,607,205.5
1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	2,925,494.6	4,152,320.5
1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,305,566.3	206,774.4
1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	(1,305,566.3)	(206,774.4)
1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	1,619,928.2	3,945,546.1

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

мянган төгрөг

Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,204,145.6	5,204,145.6
1.1.1.1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(174,437.9)	(174,437.9)

Дундговь аймгийн Сайнцагаан сумын Засаг даргын 2025 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,029,707.6	5,029,707.6
1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	1,619,928.2	1,619,928.2
1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,649,635.8	6,649,635.8
1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	6,649,635.8	6,649,635.8
1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(11,049.5)	(11,049.5)
1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,638,586.4	6,638,586.4
1.7 Тайлант үеийн үр дүн	3,945,546.1	3,945,546.1
1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	10,584,132.4	10,584,132.4

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

мянган төгрөг

Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	11,349,114.8	12,194,664.1
1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	9,157,629.8	10,131,543.8
1.1.1.1.03.1 Орлогын албан татвар	8,473,549.6	9,383,913.4
1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	273,425.3	314,781.2
1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	410,654.9	432,849.2
1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	151,892.7	180,351.8
1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр	258,762.1	185,942.5
1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр	0.0	66,555.0
1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	766,364.7	2,063,120.3
1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	766,364.7	714,988.2
1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.0	272,625.3
1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	1,075,506.8
1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,425,120.4	0.0
1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,174,933.5	7,787,240.1
1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	8,174,933.5	7,787,240.1
1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,294,958.7	6,171,149.3
1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,135,011.5	1,753,565.3
1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	140,291.1	213,634.5
1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,999,382.1	2,760,260.9
1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	61,350.2	57,308.4
1.1.1.2.01.1.05 Нормативт зардал	0.0	209.0
1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	197,133.3	382,485.6
1.1.1.2.01.1.07 Томилот, зочны зардал	4,520.0	9,500.0
1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	108,850.2	528,429.0
1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	648,420.4	465,756.8
1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,879,974.8	1,616,090.7
1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	3,174,181.3	4,407,424.0
1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	1,319,450.5	1,100,083.6
1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,319,450.5	1,100,083.6
1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	1,319,450.5	1,100,083.6
1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(1,319,450.5)	(1,100,083.6)
1.1.3.2 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.0	755,000.0
1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	1,854,730.9	2,552,340.4
1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,034,301.3	2,889,032.2
1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,889,032.2	5,441,372.6

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

мянган төгрөг

Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	12,821,410.9	11,920,183.8
3.1.01.1.1 Татварын орлого	11,065,410.0	10,131,543.8
3.1.01.1.2 Татварын бус орлого	1,756,000.9	1,788,640.0
3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	12,821,410.9	8,618,918.3
3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	7,721,974.5	6,763,834.7
3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,942,204.2	5,896,721.9
3.1.01.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,779,770.3	867,112.8

Дундговь аймгийн Сайнцагаан сумын Засаг даргын 2025 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

3.1.01.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,815,636.4	1,100,083.6
3.1.01.2.3 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	2,283,800.0	755,000.0
4 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	2,889,032.2
5 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	5,441,372.6

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

мянган төгрөг

Дансны нэр, төрөл		1. Тайлант он
1.1.1.1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	274,480.2
1.1.1.1.1	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	274,480.2
1.1.1.1.1.1	Тусламжийн орлого	274,480.2
1.1.1.1.1.1.1	Хандив тусламж /дотоод/	274,480.2
1.1.1.1.1.1.1.1	Нэмэлт санхүүжилтийн орлого	274,480.2
1.1.1.2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	265,595.0
1.1.1.2.1	УРСГАЛ ЗАРДАЛ	265,595.0
1.1.1.2.1.1	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	265,595.0
1.1.1.2.1.1.4	Хангамж, бараа материалын зардал	8,761.4
1.1.1.2.1.1.8	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	245,380.7
1.1.1.2.1.1.9	Бараа үйлчилгээний бусад зардал	11,452.9

3. Аудитын илрүүлэлт

3.1 Сумын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Сумын Засаг даргын 2025 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй.

3.2 Сумын нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн төсвийн шүүд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Сумын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 4 тусгай сангийн нийт 6 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 1 байгууллага, 4 сан түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт өгсөн байна.

Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл:

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлагттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	Засаг даргын Тамгын газар	1	1			1			
2	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	1		1					
3	Мал хамгаалах сан	1		1					
4	Хоршоо хөгжүүлэх сан	1		1					
5	Орон нутгийн хөгжлийн	1		1					
6	Байгаль хамгаалах сан	1		1					
	НИЙТ	6	1	5		1			

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 1,346,236.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 869.9 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 8,990.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1,136,376.1 мянган төгрөгийн 3 зөрчлийг арилгах албан шаардлага, 200,000.0 мянган төгрөгийн зөвлөмжийг тус тус хүргүүлсэн байна.

Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн 99.9 хувийг залруулагдаагүй, 0.1 хувийг залруулсан алдаа эзэлж байна.

Нийт 1,345,366.1 мянган төгрөгийн зөрчлөөс залруулагдаагүй 400,000.0 мянган төгрөгийн зөрчил нь нийцлийн аудитын асуудал байна. Үлдсэн санхүүгийн асуудлын 945,366.1 мянган төгрөгийн зөрчлөөс 2,510.0 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн тайлантай холбоотой асуудлыг тооцоо нийлж актыг баримтжуулж ирүүлсэн.

Харин санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдах боломжгүй, аудитын дүгнэлтэд нөлөөлөх 942,856.1 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг түвшнээс 8 дахин их тул нэгтгэсэн санхүүгийн тайланд “ХЯЗГААРЛАЛТТАЙ” дүгнэлт өгсөн.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл:

/мянган төгрөг/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хоршоо хөгжүүлэх сан	1	869.9			1	869.9	1	869.9				
Дүн	1	869.9			1	869.9	1	869.9	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл:

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	1	2,510.0			1	2,510.0						
Хоршоо хөгжүүлэх сан	1	8,990.0	1	8,990.0								
Төсөв төвлөрүүлэн захирагч	1	933,866.1			1	933,866.1						
Нийт дүн	3	945,366.1	1	8,990.0	2	936,376.1			-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал:

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил:												
Засаг даргын Тамгын газар	1	200,000.0			1	200,000.0						
Хоршоо хөгжүүлэх сан	1	200,000.0					1	200,000.0				
Нийт дүн	2	400,000.0			1	200,000.0	1	200,000.0	-	-	-	-